

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2024.07.08

Улсын бүртгэлийн байгууллагын дотоод аудитын нэгж нь Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар бөгөөд дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 1 орон тоотойгоор 2024 онд ажиллаж, дотоод аудитын чиглэлээр 2024 онд хийгдэж буй ажлыг толилуулж байна.

**Нэг. Улсын бүртгэлийн байгууллагын 2023 оны  
санхүүгийн тайлангийн жилийн эцсийн аудитын дүгнэлт**

Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгж болох Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 21 аймгийн орон нутгийн хэлтэс нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч нэгтгэлийг танилцуулж байна.

**1. 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ  
АРИЛГАХ ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА, АКТ**

Улсын бүртгэлийн 23 нэгжийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны аудитын дүгнэлтийг нэгтгэн харуулахад:

№	Нэгжийн нэр		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Үнийн дүн /мян.төг/	Тоо	Үнийн дүн /мян.төг/	Тоо	Үнийн дүн /мян.төг/
1	Архангай	Өөрчлөлтгүй			1	3,326.5		
2	Баян-Өлгий	Түүвэр	-		-		-	
3	Баянхонгор	Өөрчлөлтгүй	-		-		-	
4	Булган	Өөрчлөлтгүй	1	326.6	2	3,849.5	1	61,266.4
5	Говь-Алтай	Өөрчлөлтгүй	-		-		-	
6	Говьсүмбэр	Өөрчлөлтгүй	-		-		-	
7	Дархан-Уул	Өөрчлөлтгүй					3	6,513.1
8	Дорноговь	Түүвэр						
9	Дорнод	Түүвэр	-		-		-	
10	Дундговь	Өөрчлөлтгүй	-		-		-	
11	Завхан	Түүвэр	-		-		-	
12	Орхон	Өөрчлөлтгүй	2	1,400.7	-		2	72,023.0
13	Өвөрхангай	Өөрчлөлтгүй	-		-		-	
14	Өмнөговь	Түүвэр	-		-		-	
15	Сэлэнгэ	Зөрчилгүй	-		1	7,700.4	-	
16	Сүхбаатар	Өөрчлөлтгүй					1	-
17	Төв	Өөрчлөлтгүй	-		-		-	
18	Увс	Өөрчлөлтгүй	-		-		-	
19	Ховд	Өөрчлөлтгүй	-		-		-	
20	Хөвсгөл	Түүвэр	-		-		-	
21	Хэнтий	Түүвэр	-		-		-	

22	НУБГ	Өөрчлөлтгүй					4	10,577.3
23	УБЕГ	Хязгаарлалттай	3	49,919.9	5	1,555,828.0	12	40,107,300.0
<b>НИЙТ</b>			<b>6</b>	<b>51,647.2</b>	<b>9</b>	<b>1,570,704.4</b>	<b>23</b>	<b>40,257,679.8</b>

Улсын бүртгэлийн 23 байгууллагын 22 нэгж нь 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Харин Улсын бүртгэлийн ерөнхий газар нь “Хязгаарлалттай” дүгнэлт авсан.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын 5. “Санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээ, аудит хийх шатлал болон хэлбэр” заалтын 5.3.2.”санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, аудит хийсэн санхүүгийн тайлангийн талаар бие даасан дүгнэлт гаргалгүй, аудитын дүнг дээд шатны байгууллагад хийсэн аудитын дүнд оруулж тайлагнах аудит” хэсгийн үндэслэн 7 хэлтэс нь түүврийн аудит хийгдсэн.

Улсын бүртгэлийн байгууллагад Төрийн аудитын байгууллагаас нийт 38 алдаа, зөрчлийн дүгнэлт ирүүлсэн байна.

Илэрсэн алдаа, зөрчлийг төрийн аудитын нэгдсэн сан fas.audit.mn-д байршуулах, холбогдох нэгжүүд хугацаанд нь биелэлтийг нотлох баримт, дэмжих материалын хамт илгээх, чанартай үнэлгээнд хяналт тавин ажиллаж байна.

## 2.АКТ

№	Нэгжийн нэр	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц
1	Булган	Хэлтсийн даргад үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг дарга, УБЕГ-ын даргын шийдвэрээр 30 хувиар давхардуулан олгосон.	6 сарын 10-ны дотор	Fas.audit.mn-д байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
2	Орхон	Ээлжийн амралтын нөхөн олговор авсан ажилтанд цалин давхардуулан олгосон. Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон.	6 сарын 01-ны дотор	Fas.audit.mn-д байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
3	УБЕГ	Тайлант онд нэр бүхий 15 албан хаагчдад цалинг илүү олгосон Тайлант онд нэр бүхий 6 албан хаагчдад цалинг илүү олгосон. Олон улсын үнэт цаасны үзэсгэлэнд оролцох эрх авахаар нэр бүхий албан хаагчид шилжүүлсэн боловч буцаан төвлөрүүлээгүй.	9 сарын 02-ны дотор	Хугацаа болоогүй.

## 3.АЛБАН ШААРДЛАГА

№	Нэгжийн нэр	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц
---	-------------	---------------	---------------------	------------------

1	Архангай	Бичиг хэргийн зардлаас 2218.6 мян.төг, шуудан холбоо интернэтийн төлбөрөөс 681.0 мян.төгрөг нийт 2899.6 мян.төгрөгийг тээвэр шатахууны зардалд, цэвэр бохир усны зардлаас 426.9 мян.төгрөгийг гэрэл, цахилгааны зардалд тус тус шилжүүлж зориулалт бус зарцуулалт гаргасан.	06.15-ны дотор	Fas.audit.mn-д байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
2	Булган	Хөрөнгийн элэгдлийг тооцож санхүүгийн тайланд зардлаар тусгаагүй.	8.10-ны дотор	Fas.audit.mn-д байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
		Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого болон холбогдох тушаал шийдвэр хэсэгт огт мэдээлэл байршуулаагүй.	6.10-ны дотор	
3	Сэлэнгэ	Цалингийн урьдчилгааны 24368.2 мян.төгрөгийг давхардуулан тайлагнаж, НДШ 5848.4, ХХОАТ 1852.0-ыг илүү шилжүүлсэн боловч авлага үүсгэлгүйгээр шууд зардлаар тайлагнасан.	6.15-ны дотор	Үнэлгээ хийгдээгүй байна.
4	УБЕГ	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-с худалдан авсан гадаад паспортын бэлдцээс 20116 ширхэг алдаатай бэлдцийн үлдэгдлийг үйлдвэрээс шалтгаалсан эсвэл техникийн алдаа эсэхийг хянаж шийдвэрлээгүй.	9.02-ны дотор	Хугацаа болоогүй.
		Баталсан төсвөөс 3.5 сая төгрөгийг тэмцээний зардалд, 6.9 сая төгрөгийг биеийн тамирын хувцас худалдан авахад, 10.1 сая төгрөгийг хоол, бусад зардалд спортын арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан байна.		
		Үндсэн үйл ажиллагааны зардлаас малчинд 7.5 сая төгрөгийн цалин, ажил олгогчоос 941.2 мян төгрөгийн НДШ төлж зориулалт бусаар зарцуулсан байна.		
		Смарт карт ХХК-тэй 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 2 сарын хугацаатай байгуулсан "Гадаад паспортын хэвлэх машины хор болон хорны сав, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэж баталгаажуулахгүйгээр санхүүжилтийг бүрэн шилжүүлж, зарлагаар тайлагнасан.		
		Тайлант онд бэлэг дурсгалын зүйл, ажилчдын шинэ жилийн арга хэмжээнд 1466.6 мян төгрөг, хүлээн авалтын төлбөрт 10343.8 мян төгрөг, спортын арга хэмжээнд 5132.0 мян төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.		

#### 4.3ӨВЛӨМЖ

№	Нэгжийн нэр	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц
---	-------------	---------------	---------------------	------------------

1	Булган	Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 20 нэр төрлийн 61266.4 мян.төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй	10.01-ны дотор	Fas.audit.mn-л байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
2	Дархан-Уул	Батлагдсан төсвөөс дүрэмт хувцас болон бусад хувцас хэрэглэл авахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	05.30-ны дотор	Fas.audit.mn-л байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
		Санхүүгийн тайланд тусгаагүй газрыг үнэлж, биет бус хөрөнгөөр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулах журам"-ын 1.3-т заасныг хэрэгжүүлж, санд төвлөрүүлэх хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгах.		
3	Орхон	Тээвэр шатахууны зардлыг бараа материалын дансаар дамжуулахгүйгээр шууд зардал болгон бүртгэсэн.	06.10-ны дотор	Fas.audit.mn-л байршуулж явцаар биелэлтийг 100 хувь хангасан.
		Шилэн дансанд 2 мэдээлэл хугацаа хоцроож, 70848.0 мөн.төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй байна.		
4	Сүхбаатар	Барилгын салшгүй хэсэг болсон газрыг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулах	5.30-ны дотор	90 хувь биелэлттэй. /Газрын гэрчилгээ гараагүй учир/
5	НУБГ	Ажиллагсадтай холбоотой авлага, НДШ авлага барагдуулаагүй.	8.30-ны дотор	Хугацаа болоогүй.
		НДШ авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.		
		ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.		
		Цаг бүртгэлийн хяналт сулаас цалинг дахин бодож НДТайланд цалинг 6 удаа нийт 4593.0 мян.төгрөгөөр өөрчлөн тайлагнасан.		
		Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1168.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 1125.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 351.6 сая төгрөгийн тавилга, 27.0 сая төгрөгийн эд хогшил, 273.3 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, программ хангамж, нийт 421 нэр төрлийн 1324 ширхэг үндсэн хөрөнгө үлдэгдэлтэй байна.		
		Голомт банкны 3 дансны "Арилжааны банканд данс нээх зөвшөөрлийн гэрээ"-ний хугацаа дууссан байна.		
		Гадаад паспортыг анх болон давтан авсан, хугацаа дууссан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, хэдэн ширхэг хэвлүүлснийг бүртгэлийн цахим сүлжээнээс санхүүгийн тайланд татан авч тооцоо бодох боломжгүй байна.		
		Тайлант хугацаанд нийт 12299 ширхэг гадаад паспортын бэлдцийг техникийн алдаа гэж зарлага болгосон байна.		
		Татварын цахим системийн тодорхойлолтоор уг дүнгээр өр төлбөр, авлагын үлдэгдэлтэй байна.		

6	УБЕГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/2489 дугаар албан бичгээр УБЕГ-ын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 859м2 талбай бүхий нэгж талбараас 402м2 талбай бүхий газар эзэмших эрхийг салган Арьсны өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн эзэмшүүлэх зөвшөөрлийг олгосон боловч нягтлан бодох бүртгэлээс хасаагүй, өөрчлөгдсөн газрын гэрчилгээ, кадастрын зургийг гаргуулаагүй байна.	9.02-ны дотор	Хугацаа болоогүй.
		Засгийн газрын 2023 оны 69 дүгээр тогтоолоор Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийг баталж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 31598.4 сая төгрөгөөр тодорхойлсон боловч нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 51 хувь болох 16115.2 сая төгрөгийн хөрөнгийг УБЕГ-аас шилжүүлэх талаар ТӨБЗГ-ын шийдвэр гараагүй, 49 хувь болох 15483.2 сая төгрөгийн хөрөнгийг Мигасон ХХК-с хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй, тус компанийн 23068.8 сая төгрөгийн хөрөнгийг үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж байна.		
		Мигасон ХХК-ийн хувь нийлүүлсэн 49 хувь болох 15483.2 сая төгрөгийн хөрөнгө нь тодорхойгүй байхад Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, тус компанийн гүйцэтгэх захиралтай үйл ажиллагаанд ашиглаж байгаа нийт 23068.8 сая төгрөгийн хөрөнгийг түрээслэх гэрээ байгуулж, түрээсийн 2618.0 сая төгрөгийн өр төлбөрийг тайлагнасан байна.		
		тайлант оны эцэст байгууллагын харилцахаас үндэсний цахим болон энгийн гадаад паспортын түүхий эд материал худалдан авах зардлыг урьдчилж шилжүүлсэн байна.		
		УБЕГ-т бэлдэц тээвэрлэдэг авто машины жолоочийн замын хуудсыг хөтлөөгүй. Шатахууны тооцоог бодоогүй, бараа материалын дансаар дамжуулалгүй, шууд зардлаар тайлагнасан.		
		Албан хаагчдын цалинд ярианы төлбөрийн нэмэгдлийг тооцож олгосон.		
		Тайлант хугацаанд кассаас зарим ажилчдын цалин, материал худалдан авах, өр төлбөр төлөх гэх мэт бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийсэн байна.		

#### 5. АЛДАА, ЗӨРЧЛИЙН НИЙТЛЭГ БАЙДЛЫГ АНГИЛАН ХАРУУЛБАЛ:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт 23 нэгжээс 22 нэгж нь “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авч, аудитын дүгнэлтээр нийт 18 зөрчил илэрсэн ба үүнээс 2 нэгжид 3 акт, 3 нэгжид 4 албан шаардлага, 5 нэгжид 11 зөвлөмжийг тус тус ирүүлснийг нэгтгэн, шинжлэхэд:

№	Алдаа, зөрчлийн ангилал	Зөрчлийн тоо
1	Төсвийн тухай хууль	21
2	НББТХ	6

3	Засгийн газрын тогтоол	2
4	Шилэн дансны тухай хууль	2
5	Газрын тухай хууль	2
6	ТБОНӨТХ	2
7	Сангийн сайдын тушаал	1
8	Компанийн тухай хууль	1
9	Төрийн хэмнэлтийн тухай хууль	1
<b>НИЙТ</b>		<b>38</b>

Нэгжүүдэд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн 55 хувийг эзэлж байгаа Төсвийн тухай хууль зөрчсөн ангилалд багтсан алдааг жагсаахад:

- ! Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй;
- ! Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй;
- ! Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй;
- ! Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байхыг тус тус мөрдөөгүй байна;
- ! Ажилчдад илүү цалин олгосон;

Бусад хууль зөрчсөн ангилалд

- ! Анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу;
- ! Үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг даргын урамшуулалтай давхардуулан олгосон;
- ! Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулсан;
- ! Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон;
- ! Хөрөнгийн элэгдлийг тооцож санхүүгийн тайланд зардлаар тусгаагүй;
- ! Элэгдэж дууссан хөрөнгийг дахин үнэлээгүй;
- ! Батлагдсан төсвөөс хувцас, хэрэглэл авсан;
- ! Шилэн дансны мэдээлэл хоцроон байршуулсан гэсэн алдаа, зөрчил гаргасан байна;
- ! Цалин, материал худалдан авах, өр төлбөр төлөхдөө зардлын дансаар бүртгэсэн;

6.СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН БАЙДЛААР УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ


Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2023 онуудад Төрийн аудитын байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангаар илрүүлсэн алдаа, зөрчлийг жагсаахад:

№	Нэгжийн нэр	АКТ 2021-2023	АШ 2021-2023	ЗӨВ 2021-2023	НИЙТ АЛДАА ЗӨРЧЛИЙН ТОО
1	Архангай	-	3	1	4
2	Баян-Өлгий	-	-	-	-
3	Баянхонгор	1	1	3	5


4	Булган	2	5	6	13
5	Говь-Алтай	1	3	1	5
6	Говьсүмбэр	1	-	3	4
7	Дархан-Уул	-	-	6	6
8	Дорноговь	-	-	2	2
9	Дорнод	-	-	3	3
10	Дундговь	-	-	-	-
11	Завхан	-	-	1	1
12	Орхон	2	1	7	10
13	Өвөрхангай	-	-	1	1
14	Өмнөговь	-	1	4	5
15	Сэлэнгэ	2	4	3	9
16	Сүхбаатар	-	-	2	2
17	Төв	1	4	1	6
18	Увс	-	-	-	-
19	Ховд	-	-	3	3
20	Хөвсгөл	-	-	2	2
21	Хэнтий	1	-	1	2
22	НУБГ	-	-	12	12
23	УБЕГ	3	8	12	20
<b>НИЙТ</b>		<b>14</b>	<b>30</b>	<b>74</b>	<b>118</b>

Дээрх дүгнэлтийг үндэслэн 3 жил дараалан зөрчилгүй ажилласан Баян-Өлгий, Увс, Дундговь аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийг урамшуулах, 2021-2023 онуудад давтагдсан зөрчил гаргасан Булган, Орхон аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийг сануулах арга хэмжээ авах саналыг удирдлагад хүргэсэн.


### 2021-2023 онуудын нийт алдаа, зөрчлийн мөнгөн дүнг графикаар харуулбал



### 2021-2023 онуудын нийт алдаа, зөрчлийг графикаар харуулбал



### Сүүлийн 3 жилийн нийт алдаа, зөрчлийн тоо



#### Хоёр.Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн ажлын тайлан

- ✓ Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны дотоод аудитын 10 чиглэлийн арга хэмжээ төлөвлөн батлуулсан.
- ✓ Ховд аймгийн УБХ-ийн нэр бүхий 13 албан хаагч гарын үсэг зурж, “Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Тамгын газрын дарга



- Г.Цолмон, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин нарт” хандан 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хянан шалгах 10 асуудлын хүсэлт ирүүлсний дагуу УБЕГ-ын дарга үүрэг даалгавар өгч, Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын дарга Т.Гантөмөр, ахлах мэргэжилтэн С.Энхнаран нар тус хэлтэст 2023 оны 01 дүгээр сарын 14-нөөс 16-ны хооронд ажилласан. Албан хаагчидтай биечлэн уулзалт, ярилцлага хийн тэмдэглэл үйлдэж, тайлан бүртгэл, анхан шатны баримтуудыг үзэж, баталгаажуулж, үр дүнг илтгэх хуудсаар эрх бүхий албан тушаалтан нарт хүргүүлсэн.
- ✓ Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг 2024 оны 02 дугаар сарын 21-23-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Тус нэгжид хийгдсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг илтгэх хуудсаар УБЕГ-ын даргад танилцуулан, 2024.03.14-ний өдрийн 7/3290 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийг гаргуулан авч хэрэгжилтийг тооцон, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.
  - ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох дүрэм, журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу “Улсын бүртгэлийн байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагаа”-нд дотоод аудит хийж, илэрсэн асуудалд чиглэсэн 8 зөвлөмжийг хугацаатай өгч, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгч ажилласан.
  - ✓ Улсын бүртгэлийн 39 нэгжээс 2024 онд сар бүр, улирал бүр ирүүлэх статистик мэдээ, тайлангийн батлагдсан хуваарийг боловсруулан танилцуулсан.
  - ✓ Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны 01, 02 дугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн.
  - ✓ Улсын бүртгэлийн байгууллагын эрсдэлийн төлөвлөгөөг 13 үзүүлэлтээр тодорхойлон батлуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний биелэлтийг тооцон ажиллаж байна.
  - ✓ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 тушаалаар шинэчлэн батлагдсан “Харъяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх менежментийн төлөвлөгөөг удирдлага болгон Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан удирдлагад танилцуулсан. Улсын бүртгэлийн бүх газар, нэгжүүдэд төслийг танилцуулж, санал ирүүлэх тухай 05 дугаар сарын 20-ны 7/6819, 7/6804 дугаартай албан бичиг, 396 дугаартай дотоод албан бичгийг тус тус хүргүүлж, ирүүлсэн саналыг 05 дугаар сарын 27-ны дотор нэгтгэн удирдлагад танилцуулсан. Эрсдэлийн менежментийн сургалтад тус оны 06 дугаар сард хамрагдаж, 2024 оны эрсдэлийн төлөвлөгөөний төслийг нарийвчлан хэлэлцүүлсний эцэст батлуулах саналыг удирдлага дэмжсэн.
  - ✓ УБЕГ-ын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын зарим заалтын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах УБЕГ-ын даргын 2024 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн “Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмын зарим зүйл хэсгүүдийн хэрэгжилтэд дотоод аудит хийх ажлын удирдамж”-ийн хүрээнд Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс аймгуудын улсын бүртгэлийн хэлтсийн төрийн

албан хаагчдын цалингийн нэгдсэн систем болон хүний нөөцийн удирдлагын системд төлөвлөгөөт шалгалтыг хийж, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, хүсэлт авах, ажил сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой дотоод аудит гүйцэтгэж холбогдох нэгжүүдэд хугацаатай 10 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хүлээн авсан.

- ✓ УБЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨОХХК-ийн холбогдох зарим мэдээллийг гаргуулан авч, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, хүсэлт авах, ажил сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор ажиллан, хугацаатай 15 зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Мэдээллийн Аюулгүй Байдлын Газраас 2024 оны 06 дугаар сард Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт хийсэн “Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”-нд хийсэн тайланг хүлээн авч эрсдэлийг бууруулах 64 арга хэмжээтэй эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулан, зөвлөмжийн хамт хүргүүлэн ажилласан.
- ✓ УБЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх” удирдамжийн хүрээнд Санхүү, аж ахуйн хэлтсээс холбогдох мэдээллийг гаргуулан авч, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал, хүсэлт авах, ажил сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор дотоод аудит хийж, хугацаатай 22 зөвлөмж хүргүүлсэн.

#### **Гурав. БУСАД**

- ✓ Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 9 дүүргийн улсын бүртгэлийн санхүүгийн ажилтан, албан хаагчдад “Анхан шатны баримт бүрдүүлэлт, тайлан мэдээ бэлтгэн гаргах нь” сэдэвт танхимын сургалтыг 03 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.
- ✓ Олон улсын стандартын академийн “Эрсдэлийн менежментийн тогтолцооны MNS ISO 31000:2022 стандарт”, “MNS ISO 19011:2020 стандарт”-ын мэргэшүүлэх дотоод аудитын сургалтад 2024 оны 06 дугаар сарын 03-наас 06 дугаар сарын 06-ны өдрийн хооронд нийт 23 албан хаагчид хамрагдан амжилттай төгсөж, гэрчилгээ авсан.

#### **БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

~~~oOo~~~